

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 7.6 тэрбум төгрөг орж, урьд оны мөн үеэс 31.3 хувиар буюу 1.8 тэрбумаар дээгүүр байна.

Баруун-Урт, Уулбаян сумдын төсвийн орлогын төлөвлөгөө нь 9.4-34.2 хувиар тасарсан байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 6.4 тэрбум төгрөг болж, урьд оны мөн үеэс 1.2 тэрбум төгрөгөөр дээгүүр байна.

2397.7 сая төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт хийгдсний дотор 1068.6 сая төгрөг нь нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээнд, 672 сая төгрөг нь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын салбарт, 539.4 сая төгрөг нь барилгын салбарт, 48.6 сая төгрөг нь эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт, 43.9 сая төгрөг нь боловсролын салбарт, 25.2 сая төгрөг нь ХАА-н салбарт тус тус оржээ.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 32.8 тэрбум төгрөгт хүрсэн нь 2010 оны жилийн эцсээс 13.2 тэрбум төгрөгөөр, урьд оны мөн үеэс 15.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн хадгаламжийн хэмжээ 15.4 тэрбум төгрөг болсон нь 2010 оны жилийн эцсээс 4 тэрбум, урьд оны мөн үеэс 5.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 84.6 хувь болох 726.1 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.1 хувь болох 724.1 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 75.2 мянгаар дээгүүр байна.

Оны эхний малын 2.3 хувь болох 45.8 мянган том мал зүй бусаар хорогдсон нь урьд оны мөн үеэс 5.3 мянгаар олон байна.

Газар тариалан: Төмс 600.8 тн, хүнсний ногоо 188.5 тн-ыг хураагаад байгаа нь урьд оны мөн үеэс төмс 327.7 тн, хүнсний ногоо 57.3 тн-оор тус тус дээгүүр байна.

Байгалийн хадлан 9.5 мянган тн, тэжээлийн ургамал 15.1 тн, гар тэжээл 517.6 тн тус тус бэлтгэсэн нь урьд оны мөн үеэс хадлан 357 тн-оор доогуур, тэжээлийн ургамал 6.1 тн, гар тэжээл 87.6 тн-оор тус тус дээгүүр гүйцэтгэлтэй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 20.1 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 146.5 сая төгрөгөөр доогуур байгаагийн дотор уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 832.4 сая төгрөгөөр доогуур байна.

Оны үнээр 78.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 732.4 сая төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн 29 бүтээгдэхүүнээс 25 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн болон шинээр нэмэгдсэн байна.

V. БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО: Барилга: Барилгын байгууллагууд улсын төсвийн хөрөнгөөр 1.5 тэрбум төгрөгийн, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1.6 тэрбум төгрөгийн, бусад эх үүсвэрээр 2,0 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь урьд оны мөн үеэс 1.8 тэрбумаар дээгүүр байна.

Тээвэр: Тээвэр бүхий байгууллагууд 25571.5 мян.тн.км-ийн ачаа эргэлт, 5912.6 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийж, 3.0 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Холбоо: Холбоо ашиглалтын орлого 165.7 сая төгрөг байгаагийн дотор 77.2 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Телефон цэгийн тоо 1590 болж урьд оны мөн үеэс 55.7 хувиар өссөн байна.

VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 9-р сард өмнөх оны жилийн эцсийн түвшинд байна. Ийнхүү ижил түвшинд байхад хүнсний гол нэр төрөл, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, амралт чөлөөт цаг, соёлын бараа, согтууруулах ундаа, тамхи зэргийн үнэ, тариф нилээд буурсан нь нөлөөлжээ.

VII. СОЁЛ, БОЛОВСРОЛ: Соёл: ХЖТеатр 4.7 мянган үзэгчдэд 12 удаа тоглолт хийж, 11.6 сая төгрөгийн орлоготой ажилласан.

Музей: 1.8 мянган үзмэрээр 3.0 мянган хүнд үйлчилж, 475.6 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Нийтийн номын сан: 16.3 мянган уншигчдад 42.6 мянган номоор үйлчилж 527.5 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ.

Боловсрол: 2011-2012 оны хичээлийн жилд нийт 15 ЕБС-д 521 үндсэн багш багшилж, 368 бүлэгт 10.3 мянган сурагчид суралцаж байна. Үүнээс 1-р ангид 882 сурагч элсч, 11-р ангид 684 сурагч суралцаж байна. Аймгийн хэмжээнд нэг багшид дундажаар 20 хүүхэд ноогдож байна. 1118 сурагч дотуур байранд сууж байна.

VIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 3.9 тэрбум төгрөг болж төлөвлөгөө 16.8 хувиар өссөний дотор сайн дурын даатгуулагчид 87.9 сая төгрөгний шимтгэл оруулж, төлөвлөгөө 11.8 хувиар давж биелсэн байна. 6017 өндөр настанд 5.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгожээ. Нийгмийн халамжийн сангаас 1.2 тэрбум, улсын төсвөөс 12.2 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

IX. ЭРҮҮЛ МЭНД: Төрөлт нэмэгдэж, 951 эх амаржиж, 958 хүүхэд төрсөн нь урьд оны мөн үеэс 100 шахмаар дээгүүр байна.

Халдварт өвчнөөр 421 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 37-оор олон байгаа бөгөөд тэмбүү, заг, салхинцэцэг, мөөгөнцөр, трихоминиаз зэрэг өвчлөлүүд өссөн байна.

X. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 953 болж, урьд оны мөн үеэс 317-оор буурсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 79.5 хувь нь 16-34 насны залуучууд байна. Боловсролын хувьд 18.7 хувь нь дээд, 2.4 хувь нь тусгай дунд, 37.1 хувь нь бүрэн дунд, 7.9 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

2751 хүн шинээр бүртгүүлж, 2454 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 748 хүн ажиллаж байна.

XI. АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН, ОРЛОГО: 2-р улирлын түүвэр судалгаанд хамрагдсан 40 ААНБ-ын ажиллагчдын дундаж цалин, орлогыг авч үзэхэд: Санхүү, уул уурхай, цахилгаан эрчим хүч, тээвэр, холбоо, үл хөдлөх хөрөнгө, боловсрол, төрийн удирдлага, батлан хамгаалахын салбар өндөр үзүүлэлттэй байна.

XII. ГЭМТ ХЭРЭГ: Эхний 9 сард гэмт хэргийн үзүүлэлт анхаарал татах хэмжээнд өсч, 169 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 40.8 хувиар өслөө. Гэмт хэргийн улмаас 38 хүн нас барж, 51 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 29.4 сая төгрөгийн хохирол учирсны 27.6 саяыг нь нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 157 хүн холбогдон сэжиглэгдсэний 23.6 хувь нь согтуугаар, 19.1 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн нь урьд оны мөн үеэс 49.5-87.5 хувиар өссөн байна.

Нийт 2060 хүн эрүүлжигдэж, 103 хүн баривчлагдсан нь урьд оны мөн үеийнхээс мөн өссөн байна.

XIII. ДААТГАЛ: Даатгалын байгууллагуудын хураамжийн орлогоор 101.1 сая төгрөг орсон нь урьд оны мөн үеэс 63.7 хувиар давж биелсэн. 372 хүнд 9.8 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ.

XIV. ТӨСӨЛ: ХЭДСАН: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 13 суманд 196.7 сая төгрөгийн зээл олгосны дотор Дарьганга суманд 23.0 сая, Уулбаян суманд 25.5 сая, Сүхбаатар суманд 24.5 сая, Онгон суманд 37.8 сая төгрөгийн зээл олгосон нь хамгийн өндөр байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж 13 суманд 1.3 тэрбум төгрөгийн зээл олгож, ажлын шинэ байр 248-аар нэмэгдсэн байна.

ТА-2 төсөл: Тогтвортой амжиргаа II төслийн хүрээнд аймгийн хэмжээгээр 86.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

XV. ГАЗАР ӨМЧЛӨЛ: Оны эхний 9 сард 334 иргэн газар өмчилж авах өргөдөл өгсөнөөс 344 иргэний өргөдлийг шийдвэрлэж, 29.84 га газрыг өмчлүүлж, өссөн дүнгээр нийтдээ 5512 иргэн өргөдөл гаргаж, 5291 иргэний өргөдлийг шийдвэрлэж, 507.02 га газрыг өмчлүүлээд байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

О.ЦЭРЭНДУЛАМ — О.ЦЭРЭНДУЛАМ